БАЯН САГСАЙ АУДИТ ХХК

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО” НҮТББ

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
тасалбар болгосон санхүүгийн тайлан

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

“МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО” ТББ

АГУУЛГА	ХУУДАС
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	1
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3 – 4
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	6
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	9 – 14

“МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО” ТББ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ЕРӨНХИЙЛӨГЧ	П.Батсайхан
АЛБАН ХАЯГ	ХУД, 2-Р ХОРОО,ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ, КАПИТАЛ, 4 ДАВХАР
УТАС	976-70074003
ХАРИЛЦАГЧ БАНК	Худалдаа Хөгжлийн банк Монгол улсын арилжааны банк
АУДИТОРУУД	Баян Сагсай Аудит ХХК-ийн МНБ

МУССХ НҮТББ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний
өдрөөр дуусгавар болгосон жилийн санхүүгийн тайлангийн талаарх
удирдлагын батламж мэдэгдэл

2024 оны 02 сарын 20 өдөр

МУССХ НҮТББ-ын ЕНБД М.Энхбаатар, ерөнхий нягтлан бодогч Б.Насанбат бид тус компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгыг бүх материаллаг үзүүлэлтүүдээр Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталж байна.

М.Энхбаатар
Ерөнхий нарийн бичгийн дарга

Б.Насанбат
Нягтлан бодогч

Монгол Улс
Улаанбаатар хот

БАЯН САГСАЙ АУДИТ ХХК
АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨГӨӨ

2024 он 02 сар 23 өдөр № 24/02/03 Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

"МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО" НҮТББ-ын удирдлагад

Дүгнэлт

Бид "Монголын усан спорт сонирхогчдын холбоо" НҮТББ (цаашид "Байгууллага"гэх)-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд, Байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн, шударгаар илэрхийлсэн байна гэж дүгнэж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тайлбарласан. Бидсанхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Байгууллагаас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь байгууллагын удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Монгол улс, Улаанбаатар хот
Хан-Уул дүүрэг, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө - 34
БТТ төв, 204 тоот

Утас: 976-99090188
Цахим хаяг: www.bsaudit.mn
Цахим шуудан: munkhtsetseg@bsaudit.mn

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцооллыг хийхтэй холбоотойгоор, аудитор байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын "Төрийн бус байгууллагын тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлд заасан бүрэн эрх болох удирдлагын хүсэлтийн дагуу зөвхөн байгууллагын удирдах зөвлөлд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ Д.МӨНХЦЭЦЭГ

Монгол улс, Улаанбаатар хот
Хан-Уул дүүрэг, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө - 34
БТТ төв, 204 тоот

Утас: 976-99090188
Цахим хаяг: www.bsaudit.mn
Цахим шуудан: munkhtsetseg@bsaudit.mn

"МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО" ТББ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Тод	2022 Мян.Төг	2023 Мян.Төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3	50,126.00	85,396.90
Авлага	4		25,350.10
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5	18,668.50	20,068.50
Эргэлтийн хөрөнгийн дүн		**68,794.50**	**130,815.50**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	6	92,898.70	96,648.40
Хуримтлагдсан элэгдэл		(36,780.50)	(46,194.10)
Бусад үндсэн хөрөнгө			
Хуримтлагдсан элэгдэл			
Биет бус хөрөнгө			
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө			
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**56,118.20**	**50,454.30**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**124,912.70**	**181,269.80**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	7	3,385.50	3,385.50
Цалингийн өглөг			
Татварын өр	8	653.20	1,109.50
Бусад өглөг			
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**4,038.70**	**4,495.00**
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөрийн дүн			
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		**4,038.70**	**4,495.00**
ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
Нөөц: - хязгаарлалттүй			
- хязгаарлалттай			
Цэвэр хөрөнгийн бусад хэсэг			
Хуримтлагдсан үр дүн		120,874.00	176,774.80
Цэвэр хөрөнгийн дүн		**120,874.00**	**176,774.80**
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН		**124,912.70**	**181,269.80**

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

"МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО" ТББ

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Тод	2022 Мян.Төг	2023 Мян.Төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
Гишүүдийн татвар		60,430.00	46,170.00
Хөтөлбөр, төслийн орлого		23,190.00	63,190.20
Бэлэг, хандив, тусламжийн орлого		102,307.30	65,722.70
Бусад орлого			23,742.80
Үндсэн үйл ажиллагааны орлогын дүн		**185,927.30**	**198,825.70**
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал		201,931.60	98,358.50
Хандив, тусламж хүргэхтэй холбогдон гарсан зардал			23,000.00
Цалин хөлс, шагнал		6,012.90	7,199.10
Нийгмийн даатгалын шимтгэл		751.60	900.00
Засвар үйлчилгээний зардал			
Ашиглалтын зардал			
Түрээсийн зардал			
Албан томилолтын зардал			
Тээврийн зардал			
Элэгдлийн зардал		9,328.00	9,413.70
Зар сурталчилгааны зардал			
Шуудан холбооны зардал			264.00
Шатахууны зардал			
Бусад зардал		1,221.50	5,433.60
Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн		**219,245.60**	**144,568.90**
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН		**(33,318.30)**	**54,256.80**
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ (АЛДАГДАЛ)			
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал)		25,769.40	780.90
Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал)			967.60
Татварын зардал		(257.70)	(104.60)
ҮНДСЭН БУС АШИГ, АЛДАГДЛЫН ДҮН		**25,511.70**	**1,643.90**
Онцгой шинжтэй зүйлс (цэвэр дүнгээр)			
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН		**(7,806.70)**	**55,900.70**

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

"МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО" ТББ

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Тод	Цэвэр хөрөнгө Мян.Төг	Хуримтлагдсан үр дүн Мян.Төг	Нийт дүн Мян.Төг
2022 оны 1 сарын 1–ний байдлаар			128,680.70	128,680.70
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Залруулсан үлдэгдэл			128,680.70	128,680.70
Үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			(7,806.70)	(7,806.70)
Тайлант үеийн ашиг (алдагдал)			120,873.90	120,873.90
2022 оны 12 сарын 31–ний байдлаар				
Тайлант үеийн ашиг (алдагдал)			55,900.70	55,900.70
2023 оны 12 сарын 31–ний байдлаар			**176,774.60**	**176,774.60**

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

“МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО” ТББ

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Тод	2022 Мян.Төг	2023 Мян.Төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		**186,890.30**	**441,682.10**
Мөнгөн орлогын дүн (+)			
Гишүүдийн татвараас орсон мөнгө		60,430.00	46,170.10
Төсөл хөтөлбөрөөс хүлээн авсан		23,962.40	62,492.70
Бэлэг, хандив, тусламж		101,534.90	73,403.80
Бусад орлого		963.00	259,615.50
Мөнгөн зарлагын дүн (-)		**210,677.20**	**409,506.30**
Ажиллагчдад төлсөн		4,951.30	6,381.90
Нийгмийн даатгалын байгууллагын төлсөн		1,443.10	1,728.00
Бараа материал худалдан авахад төлсөн			
Ашиглалтын зардалд төлсөн			
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл			
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө			299,385.80
Татварын байгууллагад төлсөн		883.60	2,044.80
Бусад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд гарсан зардал		203,399.20	99,965.80
Бусад мөнгөн зарлага			
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		**(23,786.90)**	**32,175.80**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого			
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө			3,749.70
Худалдсан хөрөнгө оруулалтын орлого			
Худалдаж авсан хөрөнгө оруулалт			
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн			**(3,749.70)**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Банкнаас авсан зээл			
Улсаас өгсөн санхүүжилт			6,720.00
Хүү ба урамшууллын орлого			967.60
Валютын ханшийн зөрүү		**25,769.40**	**(842.80)**
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		**25,769.40**	**6,844.80**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		**1,982.50**	**35,270.90**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		**48,143.50**	**50,126.00**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		**50,126.00**	**85,396.90**

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

"МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО" ТББ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

1. Байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл

"Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо" ТББ (цаашид "ТББ" гэх) нь 1991 онд албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн. ТББ нь усан спорт сонирхогч иргэдийн авъяас ур чадварыг нээн хөгжүүлэх, тамирчид бэлтгэх, сургалт уралдаан тэмцээн зохион байгуулах, ижил зорилготой байгууллагуудтай хамтран ажиллах үндсэн зорилготой.
Албан ёсны хаяг: ХУД, 1-р хороо, Чингисийн Өргөн Чөлөө-48/1, Капитал Хаус, 4 Давхар.
Утас: 70074003

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

2.1 Тайлан бэлтгэх үндэслэл

ТББ-ийн санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол төгрөгөөр тайлагнасан болно.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын товчоо

(а) Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө, урт ба богино хугацаат өр төлбөрийн ангилал

ТББ нь санхүүгийн тайландаа хөрөнгийг эргэлтийн ба эргэлтийн бус, өр төлбөрийг урт ба богино хугацаат гэж ангилдаг. Хөрөнгө нь доорх тохиолдолд эргэлтийн байдаг:

- Эргэлтэд оруулахаар тооцоолж буй мөн хэвийн үйл ажиллагааны үед борлуулах зорилготой.
- Зөвхөн арилжаалах зорилгоор эзэмшиж буй.
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор төлөгдөхөөр хүлээгдэж буй, эсвэл
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор өр төлбөр төлөх болон солилцохыг хязгаарлаагүй касс ба банкин дахь данс.

Бусад бүх хөрөнгө эргэлтийн бус гэж ангилагддаг.

Доорх тохиолдолд өр төлбөр нь богино хугацаатай байна:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй.
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж буй.
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор төлөгдөхөөр хүлээгдэж буй, эсвэл
- Тайлант үеийн дараах 12 сарын дотор өр төлбөр барагдуулах хугацааг хойшлуулах нөхцөлт бус эрх байхгүй.

Компани нь бусад өр төлбөрийг урт хугацаат гэж ангилдаг.

(б) Орлого

Орлого нь гишүүдийн татвар, хөтөлбөр төслийн орлого болон бэлэг хандив, туслажийн орлогоос бүрдэнэ.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

(в) Татвар

Тайлант хугацааны орлогын албан татвар

ТББ нь Монгол Улсын Засгийн газрын дурэм журмын дагуу орлогыг татварын зорилгоор үнэлэгдэх эсвэл хасагдахгүй зүйлсийн хувьд санхүүгийн тайлагналын зорилгоор орлогынхоо дагуу одоогийн орлогын албан татварыг тогтоодог. Тайлант жилийн болон өмнөх хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан болно. Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланд биш шууд өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрнө.

Удирдлага нь татварын тайланд хэрхэн тусгах талаар татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахаар тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг бөгөөд шаардлагатай тохиолдолд сан байгуулдаг.

Хойшлогдсон татвар

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд “Тайлан тэнцлийн арга”-ыг ашиглан хойшлогдсон орлогын албан татварыг хүлээн зөвшөөрнө.

Доор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна. Хүлээн зөвшөөрөөгүй, хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно. Хэрэв тайлант хугацааны татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

(г) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхлан өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртгийг тухай бүрт нь энэ өртөгт оруулна. Үндсэн хөрөнгийн томоохон хэсгийг үе шаттайгаар солих шаардлагатай болсон үед ТББ нь ийм хэсгүүдийг тусдаа ашиглалтын хугацаа, элэгдэлтэй бие даасан хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Үүнтэй адил, үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан бол үндсэн хяналт хийх үед түүний өртгийг үндсэн хөрөнгийн бүртгэлийн дүнд оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Үндсэн хөрөнгийг дараах ойролцоолон тооцсон ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна:

Хөрөнгийн төрөл	Ашиглалтын жил
Барилга	25 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Компьютер	2 жил
Бусад	10 жил

Үндсэн хөрөнгө ба түүний томоохон хэсгүүдийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг ба алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

(д) Бичиг бус хөрөнгө

Салангид авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт (ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно) болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.
Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

(е) Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулах ба үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн тухай бүрд үнэ цэнийн бууралтын үнэлгээ хийнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулахын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулахын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой үүссэн аливаа олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(ё) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

ТББ нь тайлангийн өдөр бүр хөрөнгө үнэ цэнийн бууралтад орох шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрвээ шинж тэмдэг илэрвэл эсвэл тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг жил бүр тооцох шаардлагатай бол тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнг тооцно. Хөрөнгө нь бусад хөрөнгө, хөрөнгийн бүлгээс бие даасан, мөнгөн урсгал бий болгохгүйгээс бусад тохиолдолд тухайн хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнг хөрөнгийн эсвэл мөнгөн урсгал бий болгож байгаа хэсгийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардал ба өнөөгийн ашиглалтын үнэ цэнийг хассан дүнгийн аль ихээр тодорхойлно. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөнд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно.

Үргэлжлэн явагдаж байгаа үйл ажиллагаатай холбоотой үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн зохих (үнэ цэнэ нь буурсан хөрөнгийн ажиллагаанд хамаарагдах) зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө. Үүнд өмнө нь дахин үнэлж, дахин үнэлгээний зөрүү нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн хөрөнгүүд хамаарахгүй бөгөөд энэ тохиолдолд үнэ цэнийн бууралтын гарзыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд, өмнөх дахин үнэлгээний дүн хүртэлх хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Өмнө нь хүлээн зөвшөөрөгдсөн үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн нөхөн төлөгдөх дүнг тодорхойлогдоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана.

3. МӨНГӨН ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /мян.төг/	Эцсийн үлдэгдэл /мян.төг/
Бэлэн мөнгө	459.50	459.50
Банкин дахь мөнгө	49,666.50	84,937.40
		85,396.90
Дүн	**50,126.00**	

4. АВЛАГА

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /мян.төг/	Эцсийн үлдэгдэл /мян.төг/
Дансны авлага		
Бусад авлага		25,350.10
		25,350.10
Дүн		

5. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /мян.төг/	Эцсийн үлдэгдэл /мян.төг/
Урьдчилж төлсөн зардал	18,668.50	20,068.50
Дүн	**18,668.50**	**20,068.50**

“МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО” ТББ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

6.ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	Барилга байгууламж	Тээврийн хэрэгсэл	Газар	Компьютер болон бусад тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	Нийт дүн
ҮНДСЭН ХӨРӨНГӨ /өртөг/	Мян.Төг	Мян.Төг	Мян.Төг	Мян.Төг	Мян.Төг	Мян.Төг
2023 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл					92,898.70	92,898.70
Нэмэгдсэн дүн				3,749.70		3,749.70
Хасагдсан дүн						
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл			-	3,749.70	92,898.70	96,648.40
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ						
2023 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл		-	-		36,780.50	36,780.50
Тайлант жилд байгуулсан				149.20	9,264.40	9,413.60
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл						
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл			-	149.20	46,044.90	46,194.10
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН						
Эхний үлдэгдэл					**56,118.2**	**56,118.2**
Эцсийн үлдэгдэл			-	**3,600.50**	**46,853.80**	**50,454.30**

7. ДАНСНЫ ӨГЛӨГ

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл /мян.төг/	Эцсийн үлдэгдэл /мян.төг/
Дансны өглөг	3,385.50	3,385.50
Дүн	**3,385.50**	**3,385.50**

8. ТАТВАРЫН ӨР

Ангилал	Эхний үлдэгдэл /мян.төг/	Эцсийн үлдэгдэл /мян.төг/
ААНОАТ-ын өр	163.90	6.10
ХХОАТ-ын өр	105.30	105.30
Бусад татварын өр	384.00	998.0
Дүн	**653.20**	**1,109.40**